



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/446

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн “2019 оны төсөв батлах тухай” 2018 оны 09/10 дугаар тогтоолын 3.2, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор орон нутгийн үйлчилгээний байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүний дэд бүтэц болон орчны хүртээмжийн үнэлгээ хийхэд 1250000 (нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд шаардагдах 1250000 (нэг сая хоёр зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн сангаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100756